



## Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгүүд

- Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт тайлан
- Компанийн бизнес үйл ажиллагааны тайлан
- Компанийн 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөө
- Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт
- Компанийн аудитын хорооны дүгнэлт тайлан
- ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдэд нэр дэвшигчдийн танилцуулга, ТУЗ-ийн зардал
- Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэр
- Компанийн дүрэмд оруулсан өөрчлөлтийн тухай г.м

2016.04.15-ны 15:00 цагт БиДиСек ХК-ны байранд болно.

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН МАТЕРИАЛ



## БИ ДИ СЕК ХК

Улаанбаатар хот  
Сүхбаатар дүүрэг, 8-р  
хороо, Залуучуудын  
өргөн чөлөө 27/1  
Холбоо барих утас:  
99084025, 99012444,  
95906390

**“Э-ТРАНС ЛОЖИСТИКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН  
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2016 он 3 сар 4 өдөр

№ 16/005

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит  
хурал хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 76.1.2-т заасны дагуу “Э-транс ложистикс” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай асуудлаар хэлэлцэж, олонхийн саналыг үндэслэн **ТОГТООХ НЬ**:

1. “Э-транс ложистикс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2016 оны 04 дугаар сарын 15-ний 15:00 цагт “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн байранд зарлан хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
  - a) Компанийн тухай хуулийн 94 дүгээр зүйлд өөрчлөлт оросноор Хувьцаат компанийн дүрэмд аудитын байгууллагыг заавал ажиллуулах тухай заалт оруулах,
  - b) Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт,
  - c) Компанийн бизнес үйл ажиллагааны тайлан,
  - d) Компанийн 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах,
  - e) Компанийн аудитын хорооны тайлан,
  - f) ТУЗ-ийн гишүүдийг сонгох,
  - g) ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын зардлын төсөв,
  - h) Ногдол ашиг тараах эсэх шийдвэр танилцуулах,
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2016 оны 03 дугаар сарын 18-ны өдрөөр тогтоосугай.
4. Компанийн ээлжит хурлыг хуралдуулах шийдвэр гарсантай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг хүргэхээр 2016 оны 03 дугаар сарын 9-ны өдөр тутмын 2-оос доошгүй сонин болон хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр мэдээллэх. Энэ мэдээллийг дээрх хэлбэр шаардлагын дагуу анх мэдээллэсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа дахин мэдээллэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
5. Ээлжит хурлыг хуралдуулахтай холбогдуулан хурлын дэгийг 01 дүгээр хавсралтаар, хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь энэхүү шийдвэрийн 02 дугаар хавсралтанд заасан бичиг баримтыг ажлын өдрүүдэд 09<sup>00</sup>-17<sup>00</sup> цагийн хооронд компанийн Улаанбаатар хот дахь байранд болон “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн байранд тус тус танилцаж болохыг дурьдсугай.

6. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах "Саналын хуудас"-ын агуулгыг 03 дугаар хавсралтаар баталсугай.
7. Хувьцаа эзэмшигчээс "Санал авах хуудас"-ыг хүлээн авах сүүлийн өдрийг харъяалагдах брокер, дилерийн компаниар нь дамжуулан хурал хуралдах өдрөөс ажлын 5-с доошгүй хоногийн өмнө байхаар тогтсугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Ч.Энхболд, тооллогын комиссын даргаар Э.Ариунтуяа, гишүүдээр С.Отгонбаяр, "БиДиСЕК" ХК-ийн мэргэжилтэн Ц.Цог нарыг тус тус томилсугай.



Төлөөлөн Удирдах  
Зөвлөлийн дарга

Ч.Энхболд

**“Э-ТРАНС ЛОЖИСТИКС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД**

“Э-Транс Ложистикс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2016 оны 04-р сарын 15-ны өдөр 15:00 цагт “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн байранд болно.

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, 27/1 “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн байр

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдөр: 2016 оны 03-р сарын 18-ний өдөр

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

- a) Компанийн тухай хуулийн 94 дүгээр зүйлд өөрчлөлт орсноор Хувьцаат компанийн дүрэмд аудитын байгууллагыг заавал ажиллуулах тухай заалт оруулах
- b) Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт
- c) Компанийн бизнес үйл ажиллагааны тайлан
- d) Компанийн 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
- e) Компанийн аудитын хорооны тайлан
- f) ТУЗ-ийн гишүүдийг сонгох
- g) ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын зардлын төсөв
- h) Ногдол ашиг тараах эсэх

Хурлын материал, гарах шийдвэрийн төсөл болон холбогдох баримт бичигтэй ажлын өдрүүдэд 09:00-17:00 цагийн хооронд “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн төв оффис болон компанийн өөрийн байран дээрээс ирж танилцах боломжтой.

Холбоо барих: 95906390, 99084025, 99012444

**ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС**

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны  
3 дугаар сарын 4- ний өдрийн 16/005  
дүгээр тогтоолын “Хавсралт-1”

**“Э-ТРАНС ЛОЖИСТИКС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ**

1	Хурлын ирцийг бүртгэх (ажлын хэсэг)	15:00 – 15:10
2	Хурлын ирцийг мэдээлэх (ажлын хэсэг)	5 минут
3	Хурлын дарга хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах	5 минут
4	Хурлаар хэлэлцэх асуудлуудыг дарааллын дагуу танилцуулах,	40 минут
4.1	Компанийн тухай хуулийн 94 дүгээр зүйлд өөрчлөлт оросноор Хувьцаат компанийн дүрэмд аудитын байгууллагыг заавал ажиллуулах тухай заалт оруулах,	
4.2	Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт,	
4.3	Компанийн бизнес үйл ажиллагааны тайлан,	
4.4	Компанийн 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах,	
4.5	Компанийн аудитын хорооны тайлан,	
4.6	ТУЗ-ийн гишүүдийг сонгох,	
4.7	ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын зардлын төсөв,	
4.8	Ногдол ашиг тараах эсэх шийдвэр танилцуулах,	
5	Хувьцаа эзэмшигчид үг хэлэх, санал гаргах	20 минут
6	Санал хураалт	20 минут
7	Хурлын завсарлага	5 минут
8	Тооллогын комиссын дарга санал хураалтын дүнг танилцуулах	15 минут
9	Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах	10 минут
10	Хурлыг хаах (хурлын дарга)	5 минут

*Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны  
03 дугаар сарын 4- ний өдрийн 16/005  
дүгээр тогтоолын “Хавсралт-2”*

**“Э-ТРАНС ЛОЖИСТИКС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТАНИЛЦАЖ БОЛОХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

1. Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт тайлан
2. Компанийн бизнес үйл ажиллагааны тайлан
3. Компанийн 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөө
4. Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт
5. Компанийн аудитын хорооны дүгнэлт тайлан
6. Компанийн ТУЗ-ийн болон Гүйцэтгэх удирдлагын цалин урамшуулал болон зардлын төсөв
7. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдэд нэр дэвшигчдийн танилцуулга
8. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэр
9. Компанийн дүрэмд оруулах өөрчлөлтийн тухай

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны  
03 дугаар сарын 4- ний өдрийн 16/005  
дүгээр тогтоолын “Хавсралт-3”

**“Э-ТРАНС ЛОЖИСТИКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРАЛД САНАЛ АВАХ ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овог ..... нэр.....

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар

--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

Регистерийн дугаар

--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

Санал өгөх хувьцааны тоо .....

Бүртгэсэн / Брокер диллерийн компани / .....

Брокерийн овог ..... нэр .....

“Э-Транс Ложистикс ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2016 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 15 цагт “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн байранд болно.

№	Хэлэлцэх асуудлууд	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Санал
1.	Компанийн тухай хуулийн 94 дүгээр зүйлд өөрчлөлт оросноор Хувьцаат компанийн дүрэмд аудитын байгууллагыг заавал ажиллуулах тухай заалт оруулах				
2.	Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт				
3.	Компанийн бизнес үйл ажиллагааны тайлан				
4.	Компанийн 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах				
5.	Компанийн аудитын хорооны тайлан				
6.	ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын зардлын төсөв				
7.	Ногдол ашиг тараахгүй тухай				

Брокер ..... Гарын үсэг

/ тэмдэг /

Хувьцаа эзэмшигч ..... Гарын үсэг

2016 оны..... сар.....өдөр

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны  
03 дугаар сарын 4- ний өдрийн 16/005  
дүгээр тогтоолын “Хавсралт-3”

**“Э-ТРАНС ЛОЖИСТИКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРАЛД САНАЛ АВАХ ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овог ..... нэр.....

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар

--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

Регистерийн дугаар

--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

Санал өгөх хувьцааны тоо ..... Кумулятив саналын тоо.....

Бүртгэсэн / Брокер диллерийн компани / .....

Брокерийн овог ..... нэр .....

“Э-Транс Ложистикс ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2016 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 15 цагт “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн байранд болно.

№	ТУЗ-Д НЭР ДЭВШИГЧДИЙН НЭРС	НЭР ДЭВШИГЧДЭД ӨГӨХ САНАЛЫН ТОО
	<b>Ердийн гишүүд</b>	
1		
2		
3		
4		
5		
6		
	<b>Хараат бус гишүүд</b>	
1		
2		
3		

Брокер ..... Гарын үсэг  
/ тэмдэг /

Хувьцаа эзэмшигч ..... Гарын үсэг  
2016 оны ..... сар..... өдөр

**ТУЗ-ийн гишүүдийг сонгох санал хураалтыг кумулятив аргаар хураана.** Тус арга нь санал өгөх эрхийн нийт тоо таны эзэмшиж байгаа саналын эрхтэй энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байна. **Жишээ нь:** та 100 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг гэвэл тус компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байхад үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүн байхаар тогтоосон тохиолдолд Хувьцаа эзэмшигч эзэмшиж буй 100 ширхэг энгийн хувьцаа нь кумулятив аргаар санал өгөхөд нийт 900 саналын эрхтэй /100\*9гишүүн=900/ болох бөгөөд үүнээс 600 саналын эрхээрээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 саналын эрхээрээ ТУЗ-



ийн хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус санал өгөх эрхтэй болно гэдгийг анхаарна уу

**САНАЛ АВАХ ХУУДСЫГ АШИГЛАХ САНАМЖ**

1. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол Зуучлагч брокерийн пүүс дээр очиж хурлын материалтай танилцаад санал авах хуудсаар саналаа өгнө.
2. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч нотариатаар баталгаажуулсан байна.
3. Засварласан болон балласан, залруулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын талаарх мэдээллийг 11313108, 99012444 утсаар лавлаж болно.
5. Санал авах хуудас хүчингүй болгосон тухай шалтгаан

.....  
....

### **Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт тайлан**

“Э-Транс Ложистикс” ХК-ийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаар хэлэлцэн дүгнэснийг компанийн Хувьцаа Эзэмшигчдэд танилцуулж байна.

“Э-Транс Ложистикс” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь компанийн тухай хууль, үнэт цаасны тухай болон бусад хуулийг даган мөрдөж, холбогдох дүрэм журмын дагуу компанийн гүйцэтгэх удирдлагын багийг удирдлагаар хангаж ажилласан ба Компанийн гүйцэтгэх удирдлагын баг нь Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэр, зөвлөмжийн дагуу компанийн өдөр тутмын үйл ажиллагааг амжилттай удирдан ажиллалаа.

Төмөр замаар ачаа тээвэрлэх үйл явц нь иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын худалдан авах чадвараас ихээхэн шалтгаалдаг бөгөөд сүүлийн жилүүдэд улс орны эдийн засгийн хямрал, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын худалдан авах чадвар, бараа эргэлт багассан зэрэг нь компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна.

Гэсэн хэдий ч гүйцэтгэх удирдлагаас үйлчлүүлэгчдийг татах, хурдан шуурхай үйлчилгээг хүргэх, үйлчлүүлэхэд таатай орчинг бүрдүүлэх, үйл ажиллагаагаа сурталчилан танилцуулах зэрэг олон нийтийг хамарсан, олон төрлийн уян хатан бодлого, сурталчилгаа явуулсан ба хамт олны зүгээс ч энэхүү бодлогыг дэмжин баг хамт олон болж гар нийлж ажилласны хүчинд 2015 онд өөрийн салбар замаас ачигдсан вагоны тоог өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 2 дахин өсгөж чадлаа.

Хямралын үед компанийн зүгээс тээврийн хөлсөө нэмэгдүүлэхийг урьтал болгоогүй бөгөөд 1 вагон шилжүүлэн ачихаас олох ашгийг 2 вагон ачиж олохоор тооцоо гарган хямд үнийг баримтлан ажилласнаар 2015 онд 8,563.2 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллаж, өнгөрсөн жилээс 37%-иар өсгөж чадсанаар 61.6 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. Түүнчлэн Үндэсний татварын алба, Татварын ерөнхий газраас компанийн үйл ажиллагааг өндрөөр үнэлэн Шилдэг татвар төлөгч байгууллага “Хөх дэвтэр”-ийн эзэнээр тодрууллаа.

“Э-Транс Ложистикс” ХК-ийн Гүйцэтгэх удирдлага нь 2015 онд ажилчид хамт олноороо хүчин чармайлт гарган, ажлын үр дүн сайн ажилласан байна гэж дүгнэж байна.

### **“Э-ТРАНС ЛОЖИСТИКС”ХК ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ**

## Хэлэлцэх асуудал 1. Компанийн дүрэмд нэмэлт заалт оруулах тухай

Санхүүгийн Зохицуулах Хорооноос “Хууль, журмын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар зөвлөгөө хүргүүлэх тухай” албан бичиг ирсэн билээ. Үүнд:

Улсын Их Хурлаас Аудитын тухай хуулийг 2015 оны 6 дугаар сарын 19-ны өдөр шинэчлэн баталсантай холбогдуулан Компанийн тухай хуулийн 94 дүгээр зүйл буюу “Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд тавих аудиторын хяналт”-д дараах өөрчлөлтүүд орсон.

1. Компанийн тухай хуулийн 94.2-т “Хувьцаат компанийн дүрэмд аудитын байгууллагыг заавал ажиллуулахаар заана” гэж заасан тул 2016 оны ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурлаар дүрэмдээ нэмэлт өөрчлөлт оруулах;
2. Мөн хуулийн 94.3-т “Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн аудитын хороо /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээг батална”, 94.4-т “Энэ хуулийн 94.3-т заасан гэрээнд компанийн болон аудитын байгууллагын эрх, үүрэг, хариуцлага, аудиторт төлөх хөлсний хэмжээг заана” гэж нэмэлт өөрчлөлт оруулсан тул Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20.1.6-т “хагас жилийн болон Хороонд бүртгэлтэй аудитын байгууллагаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хугацаанд Хороо болон хөрөнгийн биржид хүргүүлэх” гэж заасны дагуу аудитын байгууллагаа сонгохдоо төлөөлөн удирдах зөвлөлийн аудитын хороогоор хэлэлцэж сонгохыг зөвлөж байна...

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлээгүй хуулийн этгээдийг энэ хуулийн 89.1.6-д заасны дагуу нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавиас дал дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, эрх бүхий албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос дөч дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, Компанийн тухай хуулийн 100.1.1-д хувьцаат компани энэ хуульд заасан тайлан тэнцэл, мэдээ, мэдээллийг нь нийтэд болон эрх бүхий байгууллага, хувьцаа эзэмшигчдэд танилцуулах, мэдээлэх, тайлангах, мэдэгдэх үүргээ биелүүлээгүй бол тухайн компанийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гучаас дөч дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, холбогдох эрх бүхий албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арваас арван тав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгох арга хэмжээ авах хуулийн зохицуулалттайг анхаарч ажиллахыг зөвлөж байна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ГАЗРЫН  
ҮНЭТ ЦААСНЫ ХЯНАЛТЫН  
ХЭЛТСИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ДОЛГОРСҮРЭН

**Хэлэлцэх асуудал 2. Санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн аудитын дүгнэлт****“НИЙСЛЭЛ-АУДИТ” ХХК**

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ХЯНАЛТЫН ИТГЭМЖЛЭГДСЭН БАЙГУУЛЛАГА

\_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ сарын \_\_\_\_\_ өдөр

Улаанбаатар хот

**ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН****Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК -ийн хувьцаа эзэмшигчдэд**

Бид Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК-ийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

**Санхүүгийн тайлангай холбоотой удирдлагын хүлээх хариуцлага**

Санхүүгийн тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх ба үнэн зөв толилуулах нь компанийн Гүйцэтгэх удирдлагын хариуцлага байдаг. Энэхүү хариуцлагад санхүүгийн ажил гүйлгээнд тохирох нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогыг сонгон авч хэрэглэх, нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг үнэн зөв хийх замаар залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлийг агуулаагүй санхүүгийн тайланг бэлтгэх, толилуулах, энэхүү үйл явцтай холбоотой дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх асуудал багтана.

**Аудиторын хариуцлага**

Хийж гүйцэтгэсэн аудит дээрээ үндэслэн энэхүү санхүүгийн тайлангийн талаар хараат бус дүгнэлт гаргах нь бидний хариуцлага юм.

Бид танай санхүүгийн тайланг материаллаг алдаагүй бэлтгэгдсэн тухай найдвартай, хангалттай нотолгоо олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, Аудитын Олон улсын Стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, тогтоомж, манай компанийн “Аудит хийх журам”-ыг баримтлан хийв. Аудит хийхдээ түүвэрлэсэн анхны баримтаас тайлан хүртэл хөөн шалгах, давтан тооцоолох, тулган баталгаажуулах, задлан шинжлэх, асууж ярилцах зэрэг аудитын горимуудыг ашиглав.

Бидний хийсэн аудит нь санхүүгийн тайлангийн талаар санал, дүгнэлтээ илэрхийлэх хангалттай үндэслэлийг бий болгосон гэдэгт итгэлтэй байна.

### Дүгнэлт

Бидний дүгнэлтээр энэхүү санхүүгийн тайлан нь 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу үнэн зөв, бодитой үзүүлсэн байна.

### Бусад

Энэ дүгнэлтийг өөр аливаа нэг этгээдэд биш, Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан, тэдний хүсэлтээр хийсэн аудитад үндэслэн гаргасан болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.

УЛААНБАТАР ХОТ  
БНДИЙН ДҮГНЭЛЭЛ АУДИТ  
ХУВИЙН  
ЗАХИРАЛ  
Т.СУГАРСҮРЭН

## САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Э-Транс ложистикс

2015 оны 12 сарын 31

(Аж ахуйн нэгж, байгууллагын нэр)

(Төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Үлдэгдэл	
		2015 оны 01-р сарын 01	2015 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	21,211,719.54	90,754,968.17
1.1.2	Дансны авлага	37,215,710.00	23,716,200.00
1.1.3	Татвар, НДШ - ийн авлага	2,452,791.69	3,692,299.12
1.1.4	Бусад авлага		
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	72,317,204.44	70,057,209.73
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/Тооцоо	1,032,418.00	
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулахаар эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө		
1.1.10	Хойшлогдсон татварын хөрөнгө		
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>134,229,843.67</b>	<b>188,220,677.01</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	5,435,608,939.09	5,171,885,092.31
1.2.2	Биет бус хөрөнгө	880,677,613.42	845,357,461.75
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	3,834,128.91	1,062,012.70
1.2.7	Хөрөнгө оруулалтын үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>6,320,120,681.42</b>	<b>6,018,304,566.76</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>6,454,350,525.09</b>	<b>6,206,525,243.77</b>
<b>2</b>	<b>Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч</b>		
<b>2.1</b>	<b>ӨР ТӨЛБӨР</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	258,365,421.00	117,205,764.00
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр	7,798,135.91	1,352,755.00
2.1.1.4	НДШ - ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат зээл	313,083,485.11	199,361,276.77
2.1.1.6	Хүүний өглөг		
2.1.1.7	Суутган татварын өглөг		
2.1.1.8	Урьдчилж орсон орлого		
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		
2.1.1.11	Борлуулахаар эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө		

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Үлдэгдэл	
		2015 оны 01-р сарын 01	2015 оны 12-р сарын 31
2.1.1.12	Хойшлогдсон татварын өглөг		
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>579,247,042.02</b>	<b>317,919,795.76</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>		
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>579,247,042.02</b>	<b>317,919,795.76</b>
<b>2.3</b>	<b>Эзэмшигчдийн өмч</b>		
2.3.1	Өмч: - төрийн		
2.3.2	- хувийн	4,620,000,000.13	4,620,000,000.13
2.3.3	- Хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	154,000,000.00	154,000,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	823,000,000.00	774,858,080.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	278,103,482.94	339,747,367.87
2.3.10			
<b>2.3.11</b>	<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>5,875,103,483.07</b>	<b>5,888,605,448.00</b>
<b>2.4</b>	<b>Өр төлбөр ба эзэмшигчдын өмчийн дүн</b>	<b>6,454,350,525.09</b>	<b>6,206,525,243.76</b>

Ерөнхий захирал \_\_\_\_\_ ( Ч.Амарсанаа )

Ерөнхий нягтлан бодогч \_\_\_\_\_ ( Э.Ариунтуяа )

Баталгаажуулсан:.....

## ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Э-Транс ложистикс

2015 оны 12 сарын 31

(Аж ахуйн нэгж, байгууллагын нэр)

(Төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2015 оны 01-р сарын 01	2015 оны 01-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)		8,444,062,065.45
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		8,036,507,956.70
3	Нийт ашиг (алдагдал)		407,554,108.75
4	Түрээсийн орлого		45,927,272.73
5	Хүүний орлого		2,419,840.01
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого		70,818,818.18
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал		347,760,203.85
11	Санхүүгийн зардал		48,339,805.22
12	Бусад зардал		
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		(17,213,595.53)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		(331,636.36)
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		(36,289,305.00)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)		76,785,493.71
19	Орлогын татварын зардал		15,141,608.78
20	Татварын дараах ашиг (алдагдал)		61,643,884.93
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг алдагдал		
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал		61,643,884.93
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн		61,643,884.93
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

Ерөнхий захирал \_\_\_\_\_ ( Ч.Амарсанаа )

Ерөнхий нягтлан бодогч \_\_\_\_\_ ( Э.Ариунтуяа )

Баталгаажуулсан:.....





## МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Э-Транс логистикс

2015 оны 12 сарын 31

(Аж ахуйн нэгж, байгууллагын нэр)

(Төгрөгөөр)

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2015 оны 01-р сарын 01	2015 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>1.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>		<b>8,626,441,486.60</b>
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		8,603,649,812.00
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		3,248,067.00
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтын орлого		
	Бусад мөнгөн орлого		19,543,607.60
<b>1.2</b>	<b>Мөнгөн зарлага (-)</b>		<b>8,275,287,629.61</b>
	Ажиллагчдад төлсөн		250,892,654.90
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө		27,681,975.00
	Бараа материал худалдан авахад төлсөн		387,970,806.00
	Ашиглалтын зардалд төлсөн		65,571,834.00
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		7,334,117,848.50
	Хүүний төлбөрт төлсөн		35,460,194.22
	Татварын байгууллагад төлсөн		124,103,307.68
	Даатгалын төлбөрт төлсөн		476,440.00
	Бусад мөнгөн зарлага		49,012,569.31
<b>1.3</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		<b>351,153,856.99</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>2.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>		<b>6,419,840.01</b>
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		4,000,000.00
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Бусад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
	Хүлээн авсан хүүний орлого		2,419,840.01
	Хүлээн авсан ногдол ашиг		
<b>2.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>		
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Хөрөнгө оруулалт эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусад олгосон зээл болон урьдчилгаа		
<b>2.3</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		<b>6,419,840.01</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>3.1</b>	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>		<b>25,870,000.00</b>
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		25,870,000.00
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
<b>3.2</b>	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>		<b>313,900,448.38</b>
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		313,900,448.38
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		
<b>3.3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		<b>(288,030,448.38)</b>
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>69,543,248.62</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>21,211,719.54</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>90,754,968.17</b>

Ерөнхий захирал ( Ч.Амарсанаа )

Ерөнхий нягтлан бодогч ( Э.Ариунтуяа )

Баталгаажуулсан:.....

## ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2015 оны 12 сарын 31

(Төгрөгөөр)

Э-Транс логистикс

Аж ахуйн нэгж, байгууллагын нэр

Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээ	Гадаад валют хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
<b>2014 оны 1-р сарын 1- ний үлдэгдэл</b>	4,620,000,000.13		154,000,000.00			823,000,000.00		5,597,000,000.13
Бүртгэлийн боллогын өөрчлөлт								
<b>Залуулсан үлдэгдэл</b>								
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)							278,103,482.94	278,103,482.94
Бусад дэлгэрэнгүй орлого								
Өмчид гарсан өөрчлөлт								
Зарласан ногдол ашиг								
Дахин үнэлгээний нэмэгдэл								
<b>2015 оны 01-р сарын 01- ний үлдэгдэл</b>	4,620,000,000.13		154,000,000.00			823,000,000.00	278,103,482.94	5,875,103,483.07
Бүртгэлийн боллогын өөрчлөлт								
<b>Залуулсан үлдэгдэл</b>								
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)							61,643,884.93	61,643,884.93
Бусад дэлгэрэнгүй орлого								
Өмчид гарсан өөрчлөлт						(48,141,920.00)		(48,141,920.00)
Зарласан ногдол ашиг								
Дахин үнэлгээний нэмэгдэл								
<b>2015 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл</b>	4,620,000,000.13		154,000,000.00			774,858,080.00	339,747,367.87	5,888,605,448.00

Ерөнхий захирал ( Ч.Амарсанаа )

Ерөнхий нягтлан бодогч ( Э.Ариунтуяа )

Баталгаажуулсан:.....

### Хэлэлцэх асуудал 3. Компанийн бизнес үйл ажиллагааны тайлан

“Э-Транс” ХХК нь 2007 оноос ачаа шилжүүлэн ачих төсөл хэрэгжүүлж эхлэн 2009 онд ашиглалтанд оруулсан бөгөөд энэхүү үйл ажиллагаагаа компаниас тусгаарлан “Э-Транс Ложистикс” ХХК-нд шилжүүлсэнээр 2010 оноос одоог хүртэл үйл ажиллагаагаа тасралтгүй амжилттай явуулсаар ирлээ.

Тус компани нь Дорноговь аймгийн Замын-Үүд сумын 1-р баг, 10-р хэсэгт буюу Хятад улсаас манай улстай хиллэж байгаа хамгийн том боомт Эрээн хотоос 10 километр, улсын хилийн хаалтаас 100 метрт байрладаг ба энэ нь үйлчлүүлэгч байгууллага, иргэнд хамгийн тохиромжтой байрлалд тооцогддог.

Зураг 1. Компанийн байршил



Манай компанийн үндсэн үйл ажиллагаа нь иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ачаа, барааг төмөр замаар тээвэрлүүлэхээр хүсэлт ирүүлсний дагуу УБТЗ-ын харъяа Замын-Үүд өртөөнд тээвэрлүүлэх ачааны төрөл байдлаас шалтгаалан тухайн төрлийн “ ачааны “ вагоныг захиалан өөрийн салбар замаас тэдний ачаа, барааг зохих журмын дагуу ачиж хүлээн авагчид нь илгээх явдал юм. Үүнээс гадна тус компани нь гаалийн баталгаат агуулах, гаалийн нэг цэгийн үйлчилгээ, авто замаар ачаа, бараа тээвэрлэх үйл ажиллагаа зэргээр үйлчилгээнийхээ нэр төрлийг олшруулан цаашид олон улсын ложистикийн үйл ажиллагаа эрхлэх чиглэл барьж ажиллаж байна.

Э-Транс Ложистикс ХХК нь 2012 оны 4-р сард хөрөнгийн бирж дээр өөрийн хувьцаагаа арилжаалан хувьцаат компанийн статустай болж техник технологи, материал техник, ажиллах хүчээ улам өргөжүүлэх ажлын эхлэлийг тавьсан.

Зураг 2. Гаалийн нэг цэгийн үйлчилгээ бүхий оффис



Гаалийн нэг цэгийн үйлчилгээний танхим бүхий оффисын барилгыг 2012 онд барьж байгуулан улсын комисст хүлээлгэн өгсөн бөгөөд одоо тус байгууламжийн 1-р давхарт гаалийн нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх танхим / үүнд: гаалийн ахлах болон улсын байцаагч, хилийн мэргэжлийн хяналтын байцаагч нарын ажил үүргээ гүйцэтгэх өрөө тасалгаанууд, гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн нарын ажлын байр, банкууд, компанийн ачаа тээврийн алба болон цайны газар байрлана /, 2-р давхарт компанийн захиргаа удирдлагын өрөө тасалгаанууд, 3-р давхарт компанийн ажилчдын 9 айлын байр, зочид төлөөлөгчдийг байрлуулах 3 өрөө, подвальный давхарт ажилчдын хувцас солих өрөө, халуун хүйтэн ус, агуулах, фитнесийн өрөө, 6 машины гарааш тус тус байрлаж байна.

### ***Ачаа шилжүүлэн ачих терминалын үйл ажиллагаа***

Тус компанийн ажил үйлчилгээний гол хэлбэр нь ачаа шилжүүлэн ачих үйл ажиллагаа юм. Манай ачаа шилжүүлэн ачих терминаль одоогийн байдлаар Замын-Үүд суманд үйл ажиллагаа явуулж байгаа бусад терминалуудаас газар нутгийн байрлалаараа ихээхэн давуу талтай бөгөөд импортын барааг тээврийн хэрэгслээс хөдлөх бүрэлдэхүүнд, экспортын барааг хөдлөх бүрэлдэхүүнээс тээврийн хэрэгсэлд шилжүүлэн ачих үйлчилгээг үзүүлж байна. Ачаа шилжүүлэн ачих терминаль нь бүрэн хүчин чадлаараа ажиллавал 1 өдөрт 34 вагон сард 1012 вагон нийт жилд 800,000 тн

ачааг шилжүүлэн боломжтой. Манай компани нь төмөр замын ачаа тээврийн үйл ажиллагааг улам өргөжүүлэх, ачаа барааны нэр төрлийг олшруулах зорилго тавин ажиллаж байгаа бөгөөд зарим төрлийн тээврийн үйл ажиллагааг өөрийн хүч бололцоонд түшиглэн зохион байгуулан ажиллаж байна.

Зураг 3. Шилжүүлэн ачилт хийгдэж байгаа нь



Төмөр замаар ачаа тээвэрлэх үйл явц нь иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын худалдан авах чадвараас ихээхэн шалтгаалдаг бөгөөд сүүлийн жилүүдэд улс орны эдийн засгийн хэлбэлзэл, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын худалдан авах чадвар, бараа эргэлт багассан зэргээс шалтгаалан компанийн үйл ажиллагаа тодорхой хэмжээнд багассан байдал өмнөх жилүүдийн үйл ажиллагаанд судалгаа хийж үзэхэд харагддаг.

Гэхдээ энэхүү байдалд дүгнэлт хийн үйлчлүүлэгчдийг татах, хурдан шуурхай үйлчилгээг хүргэх, үйлчлүүлэхэд таатай орчинг бүрдүүлэх, үйл ажиллагаагаа сурталчилан танилуулах зэрэг олон нийтийг хамарсан олон төрлийн уян хатан бодлого, сурталчилгаа явуулсан ба хамт олны зүгээс ч энэхүү бодлогыг дэмжин баг хамт олон болж гар нийлж ажилласны хүчинд 2015 онд өөрийн салбар замаас ачигдсан вагоны тоог өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 2 дахин өссөн байгааг доорх хүснэгтээс харж болно.

Хүснэгт 1. 2012-2015 оны байдлаар ачсан вагоны тоо /сараар/

Сар	2012 он	2013 он	2014 он	2015 он
1	194	228	170	100
2	116	95	70	76
3	265	262	334	439
4	303	403	301	955
5	351	360	291	946
6	442	463	301	921
7	534	511	450	989
8	649	329	652	1062
9	600	358	451	946
10	379	436	231	647
11	305	319	132	154
12	307	117	156	134
<b>Дүн</b>	<b>4,445</b>	<b>3,881</b>	<b>3,539</b>	<b>7,369</b>

Энэ өсөлтөнд УБТЗ-ын Замын-Үүд өртөөний удирдлага, манай компанитай хамтарч ажилладаг цэх, тасаг, албадын үйл ажиллагаа ихээхэн нөлөөлсөн бөгөөд тус компани нь Замын-Үүд өртөөний удирдлагатай байгуулсан салбар зам ашиглах гэрээний үүргийн дагуу аливаа асуудлыг яриа хэлэлцээрийн замаар шуурхай, оновчтой зохион байгуулж улирал бүр салбар зам эзэмших, ашиглах гэрээний дүнгийн хурлыг зохион байгуулан хийж гүйцэтгэсэн ажилдаа үнэлэлт дүгнэлт өгч байсан нь энэхүү амжилтанд хүрэх гол нөхцөл нь болж өгсөн гэж бид дүгнэдэг.

2015 оны үйл ажиллагааны зарим онцлох тоон мэдээг хүснэгт болон графикаар харуулая.

Хүснэгт 2. 2012-2015 оны ачилтын өсөлт, бууралт

Сар	2012 он	2015 он	Зөрүү	Хувь өсөлт бууралт
Ачсан вагоны тоо	4445	7369	+2924	+39,6%
Сар	2013 он	2015 он	Зөрүү	Хувь өсөлт бууралт
Ачсан вагоны тоо	3881	7369	+3488	+47.3%
Сар	2014 он	2015 он	Зөрүү	Хувь өсөлт бууралт
Ачсан вагоны тоо	3539	7369	+3830	+51.9%

График 1. 2012-2015 оны ачилт, буултыг харьцуулсан үзүүлэлт / жилээр /





График 2. Ачилтыг ачааны төрлөөр нь ялгаж харуулсан нь:




Хүснэгт 4. Орлогыг нэр төрлөөр харуулсан нь /мян төгрөг /

Д/д	Орлогын төрөл	2014 он	2015 он	Зөрүү	Өсөлт/бууралт
1	Ачилтын орлого	4,560,723.5	8,175,370.2	3,614,646.7	44.2%
2	Буултын орлого	36,423.0	20,731.0	-15,692.0	-43%
3	Агуулах хадгалалт гарах хуудасны бусад орлого	493,271.9	247,960.9	-245,311.0	-49.7%

4	Бусад орлого	306,861.1	119,169.9	-187,695.2	-61.2%
	<b>Нийт орлого</b>	<b>5,397,279.51</b>	<b>8,563,228.0</b>	<b>3,165,948.5</b>	<b>36,9%</b>

2015 онд Улаанбаатар төмөр зам өөрийн замаар тээвэрлэх ачааны тээврийн хөлсийг ачааны нэр төрлөөс хамаарч 20-25%-иар нэмэгдүүлсэн нь манай компанийн хувьд ашиг орлогоо тооцвол үйлчилгээний тариф нэмэх зайлшгүй шаардлага гарсан. Гэхдээ манай компанийн удирдлагын баг тээврийн хөлсөө нэмэгдүүлэхийг урьтал болгоогүй бөгөөд 1 вагон шилжүүлэн ачихаас олох ашгийг 2 вагон ачиж олохоор тооцоо гарч байсан ч бид үйлчилгээний тарифаа нэмэгдүүлэлгүй Улаанбаатар төмөр замын үйлчилгээний тарифаас 20,000-30,000 төгрөгний хямд ачих болсон нь хэрэглэгчдийг татах нэгэн ажил болж ачилтын орлого 3,614,646.7 мянган төгрөгөөр нэмэгдэх нэг нөхцөл болсон.

График 3. Нийт орлогын дүн / оноор харьцуулав /



### Гаалийн хяналтын бүс

Терминаль нь 2010 оны 9 сард гаалийн хяналтын бүсээр зарлагдаж 2011 оны 04 сараас үйл ажиллагаа явуулж эхэлсэн үеэс гаалийн нэг цэгийн үйлчилгээг хяналтын бүсэд нэвтрүүлэн ажиллаж байна. Одоогийн байдлаар нэг ээлжиндээ 5-6 гаалийн улсын хяналтын байцаагч, 2 хилийн мэргэжлийн хяналтын байцаагч нарыг өрөө тасалгаа, техник хэрэгслээр хангаж гааль, мэргэжлийн хяналтын үйл ажиллагааг нэг дороос үйлчлүүлэгчдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй үзүүлэх шаардлагад нийцүүлсэн бөгөөд мөн гаалийн бүртгэгдсэн мэргэжилтэн ажиллуулахыг хүсэлт гаргасан 14 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан өрөө тасалгаа, эд хогшилоор ханган ажиллаж байна.

Гаалийн хяналтын бүсэд мөрдөгдвөл зохих дүрэм журмыг чанд мөрдөн ажиллаж байгаа бөгөөд гаалийн хяналтын талбай, орон нутгийн ачилтын талбай болон өөрийн эзэмшлийн талбайг 100% камерын хяналтанд шилжүүлсэн ба одоогийн байдлаар нийт 21 камер / түүний 4 нь хөдөлгөөнт/-аар үйл ажиллагааг хянаж байна. Мөн тус компанитай Харуул хамгаалалтын гэрээтэй ажилладаг “ Бодь санаа “ ХХК-ны




гэрээт харуул хамгаалалтын алба хаагч нарын харуулын постод 32 инчийн зурагт байрлуулан хяналтын камерыг холбож өгснөөр алба хаагч нар 24 цагаар компанийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх боломжийг бүрдүүлж өглөө.

Компани нь 24 цагаар үйл ажиллагаагаа явуулах шаардлагтай байдаг тул шөнийн цагаар ажиллах үеийн гэрэлтүүлэг маш чухал ба үүнээс гадна гаалийн хяналтын талбай болон бусад талбайг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чухал хэрэгсэл болохын хувьд урьд ашиглаж байсан кварцан гэрэлтүүлгүүдийг хүчин чадал адил ч цахилгаан бага зарцуулдаг кварцан гэрэлтүүлгээр солин нийт 400w-ийн 22 гэрэл, 200w-ийн 17 гэрэлтүүлэг ашиглан шөнийн цагаар хяналтаа тавьж ажиллаж байна. Ингэснээр гаалийн хяналтын бүс болон ачилтын талбай дахь санаатай болон санамсаргүйгээр үйлдэгдсэн аливаа зөрчлийг хяналтын камерын тусламжтай илрүүлэн цаашид учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлж байна.

Зураг 4. Гаалийн хяналтын бүс, харуул хамгаалат, хяналт



График 4. Гаалийн хяналтын бүсэд гаалийн бүрдүүлэлт хийхээр нэвтэрсэн машины тоо, хураамж



### Гаалийн баталгаат агуулахын үйлчилгээ

Тус компани нь 2010 оноос хэрэгжүүлсэн терминаль барьж байгуулах төсөлдөө 2-3 агуулах барихаар төлөвлөсний дагуу 1200м<sup>2</sup> талбайтай 1 агуулах, 1500м<sup>2</sup> талбайтай 2 агуулахыг 2010-2012 оны хооронд барьж ашиглалтанд оруулсан бөгөөд эдгээр агуулахуудаас 2 агуулахыг нээлттэй гаалийн баталгаат агуулахын зорилгоор ашиглахаар Гаалийн ерөнхий газраас зөвшөөрлөө авсан. 2015 оны байдлаар 26 төрлийн, 213,479.3 /мянган/ төгрөгийн материал, тоног төхөөрөмж хадгалуулсан байна.

### Тохжилт, үйлчилгээ

Тус компани нь гаалийн нэг цэгийн үйлчилгээг иргэдэд үзүүлж байгаагынхаа хувьд байгууллагын тохижилт үйлчилгээг чанаржуулах зорилтыг тавьж 2012 онд гаалийн нэг цэгийн үйлчилгээ, компанийн ажил үйлчилгээний оффисын барилгыг барьж улсын комисст албан ёсоор хүлээлгэн өгөн одоо энэхүү байрандаа үйл ажиллагаа явуулж байна.

Зураг 6. Компанийн гадна болон доторх ногоон байгууламж



Байгууллагынхаа гадна, дотно тохижилтын ажлыг хамт олны хүчээр хийж “Ногоон байгууламж бидний орчин” гэсэн аяныг ажилчдын дунд өрнүүлэн Монгол


улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 04-р сарын 14-ны өдөр батлагдсан “ Мод тарих үндэсний өдөр зарлах тухай ” шийдвэрийн дагуу компанийн байрны 4 хэсэг газарт 800 ширхэг шар хуайс, хайлаас, голт бор, улиас тарьснаас одоо 500 ширхэг нь ургаж байна. Мөн наран цэцэг, ерхөг, согоовор зэрэг цэцэгт ургамлыг байгууллагын хажууд тарьж ургуулсан нь энэ жилийн хамгийн сайхан байгууллагын өнгө үзэмжийг нэмсэн ажил болсон билээ.

Мөн гадна талын авто зогссолтой хэсэгт нарны зайн хураагууртай гэрэл суулгаж, гаалийн хяналтын бүсийн хаяг, байгууллагынхаа хаягыг гэрлэн хаягаар өөрчлөн гадна тохижилт өнгө үзэмжийг сайжруулсаар байгаа билээ.

### **Техник технологийн шинэчлэлт, засвар үйлчилгээ**

Ажилчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд зориулж сургалтын танхимыг шинэчилэн тохижуулж ажлын зайлшгүй хэрэгцээ шаардлагатай үзүүлэн таниулах материалуудыг байрлууллаа.

*Зураг 7. Сургалтын танхим*



Үүнээс гадна 2010 онд барьж ашиглалтанд оруулсан 2, 3-р агуулахуудын ханыг дотор талаас нь шавардаж, дээврийн төмрийг янзалж засварласан, 150тн-ны автопүүг мөн засварлаж янзалж сэргээн будсан, хяналтын болон орон нутгийн талбайд хайрга дэвсэж хатууруулан машин техник, ачаа бараа унаж эвдэрхээс урьдчилан сэргийлж ажилласан.

### **Бусад ажлын талаар**

Манай компани нь одоо үйл ажиллагаа явуулж байгаа сум орон нутагтаа дээгүүр байр эзлэх татвар төлөгч байгууллага билээ. Үүнийг ч Үндэсний татварын алба, Замын-Үүд дэх татварын хэлтсээс өндөр үнэлж 2014 онд Шилдэг татвар төлөгч байгууллага буюу Татварын албаны дээд шагнал хөх дэвтэр эзэмшигч байгууллагаар Дорноговь аймгаас 3 аж ахуйн нэгжийг шагнасны нэг нь тус компани шалгарч шагналаа гардаж авлаа.

Зураг 8. Шагнал гардаж авлаа



### **Ажилчдын нийгмийн асуудал**

Замын-Үүд суманд үйл ажиллагаагаа явуулахад ажиллах хүчний тогтвор суурьшил муу шилжилт хөдөлгөөн их байдагтай холбоотойгоо ажлын тасралтгүй үйл ажиллагаа явуулах нөхцөл байдал доголдолтой байдаг нь ажилд сөргөөр нөлөөлдөг.

Ажилчдын тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг бүрдүүлэх үүднээс ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх тал дээр түлхүү анхаарч ажиллаж шаардлагатай зээл тусламж авахад дэмжлэг үзүүлэх, нийтээр тэмдэглэн өнгөрүүлэх баярыг хамт олон, гэр бүлээрээ тэмдэглэх, спортын болон хөгжөөнт тоглоом, тэмцээн уралдаан зохион байгуулах зэрэг олон төрлийн арга хэмжээг зохион байгуулж ажилласан.

Үүнээс гадна ажлын их ачаалал, ядралтыг тайлах зорилгоор жил бүр байгууллагынхаа ажилчдыг 3-7 хоног дотоод, гадаадын аялалыг зохион байгуулж хэвшсэн. Энэ онд Байгал нуур, Итгэлт хамбын хийдээр зэрэг түүхэн дурсгалт байгалийн үзэсгэлэн бүрдсэн газруудаар аялах аялалыг зохион байгуулж ирлээ.





#### Хэлэлцэх асуудал 4. Компанийн 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлах

##### Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХУВЬЦААТ КОМПАНИЙН 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

д/д	Үндсэн үйл ажиллагаа	Хийгдэх ажил	Салбар ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн
1	1. Шилжүүлэн ачих терминал, ачаа тээврийн үйл ажиллагаа	1.1 Вагонд ачаа ачих ажлыг нэмэгдүүлэх, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх, үндсэн үйл ажиллагааг сайжруулах	Хагас вагонд арматур, big bag савалгаатай цемент гэх мэт кранаар ачигдах ачааг компаниудыг судлан тэдгээрийн захирал, ачаа илгээгч нартай уулзан хамтран ажиллах хүсэлт тавьж гэрээ байгуулах	2016 оны 3, 4-р сар	Х.Батхишиг В.Баасансүрэн
2			Автоашигчийн ажилтыг нэмэгдүүлэх поддонтой болон ДСП, хавтан модон материал, лонх, тоосго гэх мэт ачааг өмнөх онуудад ачиж байсан аж ахуйн нэгжийн судалгааг гарган хамтарч ажиллах хүсэлт тавьж гэрээ байгуулах	2016 оны 3, 4-р сард	Х.Батхишиг В.Баасансүрэн
3			Тээврийг хамгийн оновчтой хурдан шуурхай зохион байгуулж вагон ашиглалтыг багасгах	2016 он	Ачаа тээврийн алба
4			Төмөр замын удирдлагуудтай уулзан салбар замын гэрээг дүгнэн сунгах, вагон хангалтыг сайжруулах талаар ярилцаж тохиролцох	2016 оны 3 сард	Х.Батхишиг
5			Буулгалтын компаниудын хүлээн авагч нартай уулзан шинээр гэрээ байгуулах болон гэрээг сунгах асуудлыг шийдвэрлэх	2016 оны 3 сард	Х.Батхишиг Э.Ариунтуяа
6			Чингэлэг тээвэрлэх аж ахуйн нэгжийн судалгаа гаргах, тээвэрлэлтийн талаар санал солилцох	2016 оны 3 сард	Х.Батхишиг
7			Төмөр замаар тээвэрлэх ачаа тээврийн төлөвлөгөөнд тусгагдсан 4890 вагон буюу 312960 тн ачааг тодорхой хэмжээнд бууруулахгүй байдлаар шилжүүлэн ачих ажиллагааг гүйцэтгэх	2016 онд	Х.Батхишиг, ачаа тээврийн алба

8			Хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгуудыг нийт ажилтан нарт өгөх	2016 оны 1 сард	Менежер, цех, албадын дарга нар
9		1.2 Ажлын байрны хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн аюулгүй ажиллагааг дээшлүүлэх, хувь хүний ажлын хариуцлагыг сайжруулах	Хөдөлмөр хамгааллын өдөр тутмын зааварчилгыг өгч байх	2016 онд	Менежер, цех, албадын дарга нар
10	Ажилчдын хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл хэрэглэж байгаа эсэхэд хяналт тавьж шалгалт зохион байгуулах		2016 он 2, 3-р улиралд	Хөдөлмөр хамгаалал эрүүл ахуй хариуцсан зөвлөл	
11	Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн дүрэм журам зөрчсөн техник тоног төхөөрөмж, ажлын багаж хэрэгсэл, тог цахилгааны монтаж зэрэгт байнгын үзлэг шалгалт хийж зөрчлийг арилаж байх		Сард 2 удаа	Хөдөлмөр хамгаалал эрүүл ахуй хариуцсан зөвлөл	
12	1.3 Төмөр замаар бус өөр төрлийн ачаа тээврийн үйлчилгээг нэвтрүүлэх		Ачааг тээврийн хэрэгслээр тээвэрлэх боломжийг судлах, өөрийн тээврийн хэрэгслийг ажилд бэлтгэх	2016 он 2 сард	Х.Батхишиг Г.Пүрэвсүрэн Ё.Цэрэннадмид
13		Чингэлгээр ачаа тээвэрлэдэг компаниудтай харилцан хамтран ажиллах санал хүргүүлэх, судлах	2016 он 2 сард	Ч.Амарсанаа Э.Ариунтуяа	
14		Эрээнээс Замын-Үүд, Замын-Үүдээс Улаанбаатар чиглэлийн тээврийн сүлжээ байгуулах боломжийг судлах	2016 оны 2-р улирал	Ч.Амарсанаа Х.Батхишиг	
15	2. Дотоод ажил	2.1 Засвар үйлчилгээ	Гаалийн хяналтын бүсийн хяналтын талбайг аспальтлах ажлын хөрөнгийн тооцоо судалгааг гарган боломжийг тооцоолох	2016 оны 2-р улирал	Э.Ариунтуяа
16			Ачилтын өндөрлөсөн тавцанг сэргээн засварлах	2016 оны 3-р улиралд	Г.Пүрэвсүрэн, механик цех
17			Агуулахын дээврийг будаж янзлах	2016 оны 2-р улиралд	Г.Пүрэвсүрэн Цех, албад
18			Оффисын байрны дээврийг будаж янзлах	2016 оны 2-р улиралд	Г.Пүрэвсүрэн Механик цех
19			Хашааны гадна талын элсийг хусаж тэгшлэх, орон нутгийн талбайд хайрга дэвсэж услаж байх	Тухай бүр	Г.Пүрэвсүрэн Механик цех
20			Үүдний босоо гэрэлтүүлгүүдийг янзлах	2016 оны 3 сард	Г.Пүрэвсүрэн
21			2.2 Техник технологийн шинэчлэл	Боодлын болон нунтаг ачаа шилжүүлэн ачих төхөөрмжийн үнийн судалгааг гарган худалдаж авах	2016 он
22	big bag савалгаатай ачааны тээвэрлэлтэнд зориулж 10-тн-ын авто кран авах	2016 оны 6 сард		Ч.Амарсанаа Э.Ариунтуяа	
23	Дотоод ажилд хэрэглэгдэх дунд оврийн универсал трактор худалдаж авах боломжийг судлан худалдаж авах	2016 онд		Ч.Амарсанаа Э.Ариунтуяа	
24	3. Сургалт, нийгмийн хамгаалал	3.1 Сургалт соён гэгээрүүлэх ажил	Ажлын ачаалал багатай саруудад ажилчдыг компанийн зардлаар мэрэгшүүлэх сургалтанд хамруулах нөхцлийг судлан танилцуулах	2016 оны 4-р улиралд	Х.Батхишиг Э.Ариунтуяа
25			Өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэглэгдэж байгаа дүрэм журмаар сургалт зохион байгуулах	2016 он	Х.Батхишиг

26		Бусад байгууллагуудаас сургагч багш нарыг урьж ажилчдад сургалт хийлгэх	2016 он	Х.Батхишиг
27		Ажилчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор уралдаан тэмцээнийг уламжлал ёсоор зохион байгуулах	2016 он	Ж.Сайнжаргал Б.Ууганцэцэг
28	3.2 Нийгмийн хамгааллын асуудал	Компанид олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа ажилчдын хүүхдийн цэцэрлэг сургуулийн сургалтын төлбөрийг төлөх, судалгааг гаргаж танилцуулах	2016 оны 3-р улиралд	Э.Ариунтуяа
29		Ажилчдын ажлын ачаалал, биеийн ядаргааг арилгах үүднээс дотоод, гадаадын түүхэн дурсгалт, худалдаа арилжааны газар, орнуудаар аялуулах	2016 оны 3-р улиралд	Ч.Амарсанаа Э.Ариунтуяа
30		Компанийн дотоод журамд заагдсан бусад нийгмийн хамгааллын асуудлыг хэрэгжүүлэх	2016 онд	Ч.Амарсанаа Х.Батхишиг

### Хэлэлцэх асуудал 5. Компанийн аудитын хорооны тайлан

#### Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК-НЫ АУДИТЫН ХОРООНЫ ТАЙЛАН ДҮГНЭЛТ

Тус компани нь 2015 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусгавар болгон санхүүгийн байдлын тайлан, дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан тэнцлийг олон улсын стандарт болон хууль журмын дагуу бэлтгэн толилуулж, хараат бус аудитын итгэмжлэгдсэн байгууллага “НИЙСЛЭЛ АУДИТ” ХХК-иар хянуулан баталгаажуулсан.

Компанийн удирдлага, санхүүгийн үйл ажиллагаа нь борлуулалтын орлогыг зохих түвшинд нэмэгдүүлэх, өртөг зардлаа хямдруулах, үйл ажиллагааны зардлаа зохих түвшинд байлгах, өр төлбөрөө бууруулах зэрэгт үйл ажиллагаагаа чиглүүлж ажилласан байна.

Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК-ийн 2015 оны үйл ажиллагааг үзэж танилцахын зэрэгцээ жилийн эцсийн санхүүгийн тайлан, бусад холбогдох дотоод тайлан мэдээнд үндэслэн тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн байдалд үнэлэлт өгвөл:

/Мян.төгрөгөөр/

	Үзүүлэлт	2014	2015	2015 он, бүтэцээр*
<b>1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>134,229.80</b>	<b>188,220.68</b>	<b>3.0%</b>
1.1	Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө	21,211.70	90,754.97	1.5%
1.2	Авлага	39,668.50	27408.499	0.4%
1.3	Бараа материал	73,349.60	70,057.21	1.1%
<b>2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>6,320,120.70</b>	<b>6,018,304.57</b>	<b>97.0%</b>
2.1	Үндсэн хөрөнгө /цэврээр/	5,439,443.10	5,172,947.10	83.3%
2.2	Биет бус элэгдэл /цэврээр/	880,677.60	845,357.46	13.6%

<b>3</b>	<b>Нийт хөрөнгө</b>	<b>6,454,350.50</b>	<b>6,206,525.24</b>	<b>100.0%</b>
<b>4</b>	<b>Өр төлбөр</b>	<b>579,247.00</b>	<b>317,919.80</b>	<b>5.1%</b>
4.1	Дансны өглөг	258,365.40	117,205.76	1.9%
4.2	Татварын өглөг	7,798.10	1,352.76	0.0%
4.3	Богино хугацаат зээл	313,083.50	199,361.28	3.2%
<b>5</b>	<b>Эзэмшигчдийн өмч</b>	<b>5,875,103.50</b>	<b>5,888,605.45</b>	<b>94.9%</b>
5.1	Хувьцаат капитал	4,620,000.00	4,620,000.00	74.4%
5.2	Нэмж төлөгдсөн капитал	154,000.00	154,000.00	2.5%
5.3	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	823,000.00	774,858.08	12.5%
5.4	Хуримтлагдсан ашиг	278,103.50	339,747.37	5.5%
<b>6</b>	<b>Өр төлбөр ба эзний өмч</b>	<b>6,454,350.50</b>	<b>6,206,525.24</b>	<b>100.0%</b>

\* нийт хөрөнгийн дүнд эзлэх хувиар

Хөрөнгийн бүтцийг харахад нийт хөрөнгөнд эзлэх эргэлтийн бус хөрөнгийн хэмжээ 97% байгаа нь компанийн үйл ажиллагааны онцлогтой холбоотой.

Компанийн санхүүжилтийн эх үүсвэрийн 94.8% нь өөрийн эх үүсвэрээс бүрдсэн байна. 2015 оны байдлаар богино хугацаат банкны зээл 112.7 сая төгрөгөөр буюу 36.3%-иар буурсан байна. Бусад төлөх өрийн үүргийг өөрийн хөрөнгөөр хариуцах чадвар урт болон дунд, ойрын хугацаанд сайн байна.

/сая.төгрөгөөр/

Үзүүлэлт	2015	2016	Өсөлт/бууралт
Тээвэр зуучийн орлого	5,298,010	8,444,062	59.4%
Үзүүлсэн үйлчилгээний өртөг	4,819,423	8,036,508	66.8%
Нийт ашиг	478,587	407,554	-14.8%
Түрээсийн орлого	41,327	45,927	11.1%
Хүүний орлого	1,622	2,420	49.2%
Бусад орлого	57,942	70,819	22.2%
Удирдлагын зардал	375,478	347,760	-7.4%
Санхүүгийн зардал	51,894	48,340	-6.8%
Бусад	(92,461)	(53,835)	-41.8%
Татвар төлөхийн өмнөх ашиг	59,646	76,785	28.7%
Орлогын татварын зардал	16,669	15,142	-9.2%
Цэвэр ашиг, алдагдал	42,977	61,644	43.4%

Компанийн удирдлага нь үйлчилгээний хөлсийг нэмэгдүүлэхгүй байх шийдвэр гарган, хямд үнийн бодлого баримтлан ажилласнаар үйл ажиллагааны гол орлого болох тээвэр зуучийн орлого нь тайлант жил 3,146.0 сая төгрөг буюу 59,4%-иар өссөн хэдий ч нийт ашиг 14.8%-иар буурсан байна.

Түүнчлэн компаниас зардлаа бууруулах бодлого баримтлан ажилласнаар удирдлагын болон санхүүгийн зардал 6.8%-7.4%-иар буурсан үзүүлэлт гарчээ.

2015 оны жилийн эцсийн байдлаар 61.6 сая төгрөгийн ашигтай ажилласан нь өнгөрсөн жилээс 43.4%-ийн өсөлттэй байна.



**Хэлэлцэх асуудал 6. ТУЗ-ийн гишүүдийг сонгох****“Э-Транс Ложистикс”ХК-ийн  
ТУЗ-ийн хараат гишүүнд нэр дэвшигч  
Чулуун овогтой Энхболд тодорхойлолт****1. Товч танилцуулга**

Овог нэр: Чулуун овогтой Энхболд

Төрсөн он: 1967 он

Иргэний харьяалал: Монгол

Эрхэлж байгаа ажил: Э-Транс ХХК-ийн ерөнхий захирал

**2. Боловсрол**

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Төв аймгийн Зуунмод хотын 10 жилийн сургууль	Бүрэн дунд	1974	1984
2	Ленинградын Төмөр замын дээд сургууль		1984	1989
3	АНУ-д агаарын тээврийн аюултай ачаа тээвэрлэлтийн сургалт		1999	2000

**3. Ажлын туршлага**

1989-1990 онд УБТЗ-ын өртөө ажилчин

1990-1992 онд УБТЗ-ын Замын –Үүд өртөө орлогч дарга

1992-1994 онд УБТЗ-ын Багануур өртөө орлогч дарга

1992-1997 онд ТУУШИН ХХК ОУ-ын тээвэр зууч, экспортын тээвэрлэлтийн мэргэжилтэн

**“Э-Транс Ложистикс”ХК-ийн  
ТУЗ-ийн хараат гишүүнд нэр дэвшигч  
Чулуун овогтой Амарсанаа тодорхойлолт**

**1. Товч танилцуулга**

Овог нэр: Чулуун овогтой Амарсанаа

Төрсөн он: 1961 он

Иргэний харьяалал: Монгол

Эрхэлж байгаа ажил: Э-Транс Ложистикс ХХК гүйцэтгэх захирал

**2. Боловсрол**

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Ерөнхий боловсролын сургууль	Бүрэн дунд	1969	1979
2	ЗХУ-ын Свердловск хотын Уулын дээд сургууль		1979	1984
3	БНСЧС улсын Коопзинеце мэргэжил дээшлүүлсэн		1989	1990

**3. Ажлын туршлага**

1984-1985 онд Бугантын алтны үйлдвэрт засварчин, туслах эксваторчин

1985-1991 онд Цагаан дэлийн уурхай, ерөнхий механик

1991-1995 онд Монгол Чехийн хамтарсан үйлдвэр, Ерөнхий инженер дарга

1995-2002 онд Монгол Чехийн хамтарсан үйлдвэрийн харьяа Хавчуургын алтны уурхай, ерөнхий инженер дарга

2002-2011 онд Э-Транс ХХК, гүйцэтгэх захирал

2011 оноос Э-Транс Ложистикс ХХК гүйцэтгэх захирал

**“Э-Транс Ложистикс”ХК-ийн  
ТУЗ-ийн хараат гишүүнд нэр дэвшигч  
Санжмятав овогтой Отгонбаяр тодорхойлолт**

**1. Товч танилцуулга**

Овог нэр: Санжмятав овогтой Отгонбаяр

Төрсөн он: 1976 он

Иргэний харьяалал: Монгол

Эрхэлж байгаа ажил: Э-Транс ХХК, ерөнхий менежер

**2. Боловсрол**

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Ерөнхий боловсролын сургууль	Бүрэн дунд	1983	1993
2	Худалдаа үйлдвэрийн дээд сургууль	Бизнесийн удирдлага	1993	1997
3	АНУ-д агаарын тээврийн аюултай ачаа тээвэрлэлтийн сургалт		1999	2000

**3. Ажлын туршлага**

2002-2003 онд Монгол Хатгамал ХХК

2005-2006 онд Амиго Трейд ХХК

**“Э-Транс Ложистикс”ХК-ийн  
ТУЗ-ийн хараат гишүүнд нэр дэвшигч  
Баярсайхан овогтой Пүрэвбаатар тодорхойлолт**

**1. Товч танилцуулга**

Овог нэр: Баярсайхан овогтой Пүрэвбаатар

Төрсөн он: 1986 он

Иргэний харьяалал: Монгол

Эрхэлж байгаа ажил: Санхүүгийн шинжээч, “Си Би Эм” ХХК

**2. Боловсрол**

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Ерөнхий боловсролын сургууль	Бүрэн дунд	1994	2004
2	Санхүү эдийн Засгийн Дээд сургууль	Бизнес удирдлагын бакалавр	2004	2010
3	University Tomas Bata in Zlin, Czech Republic	Business Administration	2007	2009

**3. Ажлын туршлага**

2010 – 2011      Корпорацийн санхүүч, “Фронттиер Секюритис” ХХК

2011 оноос      ТУЗ-ын нарийн бичгийн дарга, “Бэрх Уул” ХК

2011 оноос      Санхүү эрхэлсэн дэд захирал, “Би Эй Пи” ХХК

**“Э-Транс Ложистикс”ХК-ийн  
ТУЗ-ийн хараат гишүүнд нэр дэвшигч  
Бадан овогтой Батбаатар тодорхойлолт**

**1. Товч танилцуулга**

Овог нэр: Бадан овогтой Батбаатар

Төрсөн он: 1977 он

Иргэний харьяалал: Монгол

Эрхэлж байгаа ажил: “СВМ” ХХК, гүйцэтгэх захирал

**2. Боловсрол**

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Ерөнхий боловсролын сургууль	Бүрэн дунд		
2	James Madison их сургууль		2000	
3	The George Washington их сургууль		2004	

**3. Ажлын туршлага**

2001-2002 онд “Кембриж ассошиэйт” ХХК, судалгааны ажилтан

2002-2005 онд “Кембриж ассошиэйт” ХХК, ахлах ажилтан

2005-2006 онд “Капитал корпораци”ХХК, дэд ерөнхийлөгч

2006-2007 онд Мянганы сорилын сан, эдийн засагч

2007-2009 онд “City Capital Partners” ХХК, санхүүгийн албаны дарга

**“Э-Транс Ложистикс”ХК-ийн  
ТУЗ-ийн хараат гишүүнд нэр дэвшигч  
Бүрэнмэнд овогтой Лхагвадорж тодорхойлолт**

**1. Товч танилцуулга**

Овог нэр: Бүрэнмэнд овогтой Лхагвадорж

Төрсөн он: 1976 он

Иргэний харьяалал: Монгол

Эрхэлж байгаа ажил: БиДиСек ХК, тэргүүн дэд захирал

**2. Боловсрол**

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Ерөнхий боловсролын сургууль	Бүрэн дунд	1983	1993
2	ШУТИС	Нефтийн инженер	1993	1997

**3. Ажлын туршлага**

1997 оноос БиДиСек ХК, тэргүүн дэд захирал

**“Э-Транс Ложистикс”ХК-ийн  
ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч  
Сэджав овогтой Санжаа тодорхойлолт**

**1. Товч танилцуулга**

Овог нэр: Сэджав овогтой Санжаа

Төрсөн он: 1959 он

Иргэний харьяалал: Монгол

Эрхэлж байгаа ажил: Мэдээлэл-Аудит ХХК, мэргэжилтэн

**2. Боловсрол**

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Ерөнхий боловсролын сургууль	Бүрэн дунд	1967	1977
2	Санхүү Эдийн Засгийн Техникум		1977	1979

**3. Ажлын туршлага**

1979-1981 онд Түлээний трест, тооцооны ба ерөнхий нягтлан бодогч

1981-1990 онд Сэлэнгэ аймаг, Дулаанхан Түнхэл, Бугантын модны үйлдвэр, ерөнхий нягтлан бодогч

1990-2001 онд Эрдэнэтийн модны үйлдвэр, ерөнхий нягтлан бодогч

**“Э-Транс Ложистикс”ХК-ийн  
ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч  
Ариунболд овогтой Батболд тодорхойлолт**

**1. Товч танилцуулга**

Овог нэр: Ариунболд овогтой Батболд

Төрсөн он: 1968 он

Иргэний харьяалал: Монгол

Эрхэлж байгаа ажил:

**2. Боловсрол**

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Ерөнхий боловсролын сургууль	Бүрэн дунд		
2	Санкт-Петербургийн төмөр замын дээд сургууль		1985	1991
3	Удирдлыагын академи	Бизнесийн удирдлагын магистр	2004	2006

**3. Ажлын туршлага**

1996-1997 онд УБТЗ-ын УБ өртөө, Холбогч найруулагч

1997 онд УБТЗ-ын олон улсын тээвэр зуучлалын төв

1997-1998 онд УБТЗ-ын өртөө Ерөнхий инженер

1998-2001 онд УБТЗ-ын ачиж буулгах тээвэр экспедицийн механикжсан анги,  
Орлогч дарга

2001-2004 онд УБТЗ-ын техник технологийн хэлтэс, Дарга

2004-2008 онд УБТЗ-ын техникийн бодлогын алба, Дарга

2008-2011 онд “Монголын төмөр зам” ТӨХК, гүйцэтгэх захирал

2011 онд УБТЗ-ын удирдах газар, даргын зөвлөх

2011 онд “Оптимальный проект”ХХК захирал



**“Э-Транс Ложистикс”ХК-ийн  
ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч  
Халтар овогтой Батхишиг тодорхойлолт**

**4. Товч танилцуулга**

Овог нэр: Халтар овогтой Батхишиг

Төрсөн он: 1974 он

Иргэний харьяалал: Монгол

Эрхэлж байгаа ажил: “Нефть Ойл” ХХК-ийн гүйцэтгэх захирал

**5. Боловсрол**

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он
1	Ерөнхий боловсролын сургууль	Бүрэн дунд		
2	ШУТИС	инженер		

**6. Ажлын туршлага**

“Нефть Ойл” ХХК-ийн гүйцэтгэх захирал

**Хэлэлцэх асуудал 7. ТУЗ-ийн зардлын төсөв****Төлөөлөн Удирдах Зөвлөлийн зардлын төсөв**

2016 оны ТУЗ-ийн зардлын төсөв

	<b>Зардлын нэр</b>	<b>Зардлын дүн /төгрөг/</b>
1	ТУЗ-ийн гишүүдийн цалин	-
2	ТУЗ-ийн нарийн бичгийн цалин	240,000
3	Зөвлөх үйлчилгээний хөлс	1,000,000
4	ТУЗ-ийн хурлын зардал	1,000,000
5	Томилолтын зардал	1,000,000
6	Бичиг хэргийн зардал	100,000
7	Бусад /ХЭХ-ийн зар гаргах/	500,000
	<b>Дүн</b>	<b>3,840,000</b>

## Хэлэлцэх асуудал 8. Ногдол ашиг тараах эсэх

### “Э-ТРАНС ЛОЖИСТИКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2016 он 3 сар 4 өдөр

№ 16/002

Улаанбаатар хот

2015 оны үйл ажиллагааны ашгаас  
Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46.5-р зүйл, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компани санхүүгийн байдалтай холбогдуулан 2015 оны үр дүнгээр хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хувиарлахгүй байхаар тогтоосугай.
2. Ногдол ашиг тараахгүй байх үндэслэлийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнахыг Гүйцэтгэх захирал /Ч.Амарсанаа/-д үүрэг болгосугай.



Төлөөлөн Удирдах  
Зөвлөлийн дарга

Ч.Энхболд

Төсөл

“Э-ТРАНС ЛОЖИСТИКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2016.04.15

№1

Улаанбаатар хот

**Компанийн дүрэмд нэмэлт заалт оруулах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, Тооллогын комиссын дүнг үндэслэн “Э-Транс ложистикс” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь**:

1. Компанийн тухай хуулийн 94 дүгээр зүйлд заасны дагуу “Э-Транс ложистикс” ХК-ийн дүрмийн .....-т “жилийн эцсийн санхүүгийн тайланд заавал аудит хийлгэх” гэсэн нэмэлт заалтыг компанийн дүрэмд оруулсугай.
2. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулж Санхүүгийн Зохицуулах Хороонд тайлагнахыг Гүйцэтгэх захирал Ч.Амарсанаа-д даалгасугай.

Хурлын дарга: ...../ /

Төсөл

“Э-ТРАНС ЛОЖИСТИКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2016.04.15

№2

Улаанбаатар хот

**Компанийн санхүүгийн тайлан,  
түүнд хийгдсэн хараат бус  
аудитын тайланг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалт, Тооллогын комиссын дүнг үндэслэн “Э-Транс ложистикс” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. Компанийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг зөвшөөрсүгэй.
2. Санхүүгийн тайланд хийгдсэн “Нийслэл Аудит” ХХК-ийн хараат бус аудитын тайланг хангалттай гэж үзсүгэй.

Хурлын дарга: ...../ /

Төсөл

“Э-ТРАНС ЛОЖИСТИКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2016.04.15

№3

Улаанбаатар хот

**Компанийн бизнес үйл ажиллагааны  
тайланг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалт, Тооллогын комиссын дүнг үндэслэн “Э-Транс ложистикс” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. “Э-Транс Ложистикс” Хувьцаат Компанийн 2015 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэж баталсугай.
2. Үйл ажиллагааны тайланд дурдагдсан ололт амжилтыг бататгаж ажиллахыг Гүйцэтгэх захирал Ч.Амарсанаа-д даалгасугай.

Хурлын дарга: ...../ /

Төсөл

“Э-ТРАНС ЛОЖИСТИКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2016.04.15

№4

Улаанбаатар хот

**Компанийн 2016 оны үйл ажиллагааны  
төлөвлөгөөг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалт, Тооллогын комиссын дүнг үндэслэн “Э-Транс ложистикс” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. “Э-Транс Ложистикс” Хувьцаат Компанийн 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталсугай.
2. Үйл ажиллагааны төлөвлөгөөний гүйцэтгэлд анхаарч ажиллахыг Гүйцэтгэх захирал Ч.Амарсанаа-д даалгасугай.

Хурлын дарга: ...../ /

Төсөл

“Э-ТРАНС ЛОЖИСТИКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2016.04.15

№5

Улаанбаатар хот

**Компанийн аудитын хорооны  
тайланг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалт, Тооллогын комиссын дүнг үндэслэн “Э-Транс ложистикс” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. “Э-Транс ложистикс” ХК-ийн Аудитын хорооны тайланг хангалттай гэж үзэсүгэй.
2. “Э-Транс ложистикс” ХК-ийн Аудитын хорооны 2015 оны тайланг хавсралт № .... баталсугай.

Хурлын дарга: ...../ /



Төсөл

“Э-ТРАНС ЛОЖИСТИКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2016.04.15

№6

Улаанбаатар хот

**Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
гишүүдийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дах заалтыг удирдлага болгон Тооллогын комиссын дүн, тогтоолыг үндэслэн “Э-Транс ложистикс” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. “Э-Транс ложистикс” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат гишүүдээр
  - 1) .....
  - 2) .....
  - 3) .....
  - 4) .....
  - 5) .....
  - 6) .....
  
2. “Э-Транс ложистикс” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдээр
  - 1) .....
  - 2) .....
  - 3) .....
  - 4) ..... нарыг тус тус Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдээр сонгогдсоныг баталсугай.

Хурлын дарга: ...../ /

Төсөл

“Э-ТРАНС ЛОЖИСТИКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2016.04.15

№7

Улаанбаатар хот

**Төлөөлөн Удирдах Зөвлөлийн  
зардлын төсөв батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалтыг үндэслэн “Э-Транс ложистикс” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ** нь:

1. “Э-Транс ложистикс” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2016 оны зардлын төсвийг ..... төгрөгөөр тогтоосугай.

Хурлын дарга: ...../ /

Төсөл

“Э-ТРАНС ЛОЖИСТИКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2016.04.15

№8

Улаанбаатар хот

**Компанийн ногдол ашиг тараахгүй тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалтыг үндэслэн “Э-Транс ложистикс” Хувьцаат Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ нь:**

1. ТУЗ-өөс танилцуулсан Ногдол ашиг хувиарлахгүй байх шийдвэрийг зөвшөөрсүгэй.

Хурлын дарга: ...../ /